

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2019 ОНЫ 12 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 12 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 823 ширхгийг шинээр хэвлэн, 382 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 52 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын хоёр иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 1176 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 1516 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 801, 7585-1882 дугаарын утсаар 5, биечлэн 280, автомат хариулагчаар 430 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Оросын Холбооны Улсын Улан-Үд дэх консулын газрын ажилтанд утсаар, найман улсын гадаадын есөн иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээр “J” ангиллын 23, “S” ангиллын 75, “A” ангиллын гурав, “B” ангиллын нэг болон хоёр удаагийн орох тав, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 52 визийн зөвшөөрөл олгож, нийт давхардсан тоогоор 128 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 71 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 127 иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын нэг мэргэжилтэн ажиллаж 56 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 24 иргэнд визийн зөвшөөрөл, 30 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 47 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 14 иргэний ангиллыг сольж, дөрвөн иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 47 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 12 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 2.5 хувиар, хувийн урилга олголт 66.7 хувиар өссөн, харин виз олголт 5.6 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 69.4 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 19.4 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 15.0 хувиар, түр ирэгчийн бүртгэл 41.2 хувиар, түр ирэгчийн хасалт 61.8 хувиар, визийн сунгалт 84.2 хувиар тус тус буурсан байна.

Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:


Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар харьяалалгүй 10 хүн Монгол Улсын харьяат болж, мөн нэг удаагийн зарлигаар харьяалалгүй 119 хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй нэг хүний хүсэлтийг хүлээн авч хянан хуульд заасан шалгуурыг хангаагүй тул буцаан хүргүүлэв.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын гурван улсын харьяат болох хүсэлт гаргасан 13 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 27 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, нэг улсын харьяат болох хүсэлт гаргасан долоон иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан нэг гурван хүний хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүлсэн ба харьяалалгүй хоёр хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээ.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн хоёр иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3555 иргэн бүртгэлтэй байна.



Мэргэжлийн зөвлөлийн хурлаар олон улсын болон гадаад улсын есөн төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгалаа. 2019 оны 12 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 89 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Гадаадын нэг гэр бүлд үрчлүүлсэн нэг хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.


### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн хоёр улсын 14 иргэнийг байгууллагын даргын дөрвөн удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын тушаалаар гадаадын нэг иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 66 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр нэг улсын найман иргэнд гарах сануулга, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг үндэслэн нэг аж ахуйн нэгжид хяналтын улсын байцаагчийн албан шаардлага өгсөн.

Тайлант хугацаанд таван удаагийн төлөвлөгөөт, 10 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 157 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 425 иргэнийг хамруулсан ба 70 гадаадын иргэн, 51 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 95 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 40,170,000 /дөчин сая нэг зуун далан мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээ.



2019 оны 12 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 8.9 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 26.3 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 50.0 хувиар тус тус буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

“Хууль зүй, дотоод хэргийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд тус байгууллагаас 2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдад, байгууллагын 2019 оны 11 дүгээр сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, байгууллагын 2019 оны 11 дүгээр сарын үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан тус байгууллагаас 2016-2018 онд хийж хэрэгжүүлсэн болон 2019 онд хийж байгаа ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу бэлтгэн шалгалтын комисст танилцууллаа. Мөн архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын 2015 оны улсын үзлэгийн мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн шалгалтын комисст хүргүүлсэн.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 26 өргөдөл, нэг гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 17 өргөдөл, нэг гомдол шийдвэрлэгдэж, есөн өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Ховд аймаг дахь Баруун бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийг дахин нягтлан шалгах, зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах зорилгоор Баруун бүс дэх газарт хяналт шалгалтын бүрэлдэхүүн ажиллалаа.

2019 онд төрийн жинхэнэ албаны нөөцөд үлдэж түр чөлөөлөгдсөн найман албан хаагчийн, “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 9.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулсан 22 албан хаагчийн судалгааг тус тус гарган албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн даргад хүргүүллээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01-03/14 дүгээр удирдамжаар Агаарын замын боомт хариуцсан газрын албан хаагчдыг 4 ээлжийн давтан сургалтад хамруулахаар болсны дагуу гуравдугаар ээлжийн давтан сургалтад дөрвөн албан хаагч хамрагдаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхлэх Дээд комиссарын газар болон Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Онцгой байдал ба дүрвэгчид” сургалтад нэг албан хаагч, “Хуулиа дээдэлсэн, иргэдээ эрхэмлэсэн төрийн албаны төлөө” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт нэг албан хаагч оролцлоо.

Эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж буй албан хаагчдыг эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах зорилгоор

Удирдлагын академиас зохион байгуулж буй “Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д зургаан албан хаагч хамрагдаж байна.

Албан хаагчдын мэдээллийн цагаар зохион байгуулсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийг тайлагнах, үнэлэх арга зүй, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх” сэдэвт сургалтад байгууллагын төвийн 62, орон нутаг дахь зургаан газрын 77 албан хаагч хамрагдав.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд холбогдох зургаан мэдээ бэлтгэн тухай бүр байгууллагын болон мэдээллийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан. Тухайлбал: “О” ангиллын визийн зөвшөөрлийг цахимаар олгож эхэллээ” мэдээ есөн цахим хуудас, нэг сонин, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнагдлаа” мэдээ гурван цахим хуудас, 75 хятад иргэний паспорт дээр “хасав” тэмдэглэгээ хийж, оршин суух үнэмлэхийг нь хураан авсан тухай мэдэгдэл, мэдээ 12 цахим хуудас, хоёр сонинд нийтлэгдсэн байна.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгуулагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Ажлын хэсгийн хуралд Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн оролцсон. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Хүн худалдаалахтай гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ын төсөлд холбогдох саналыг албан бичгээр хүргүүллээ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн Хилээр орох гарахыг хариуцах газрын орлогч дарга Баян-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид Гадаадын иргэн, харьяатын газарт албан айлчлал хийлээ.

## 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Монгол Улсын иргэнийн бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг харах программ хангамж боловсруулах ажлын хүрээнд хэрэглэгчийн шаардлага, програм хангамжийн интерфейс /харагдах байдал/-ийг хийж дуусгаад байна.

“evisa” системийн хөгжүүлэлтийн хүрээнд Виз, зөвшөөрөл, харьяатын газрын албан хаагч тус бүрээр дэлгэрэнгүй тайлан гаргах хэсгийг шинээр хийж, ажиллагаанд орууллаа.

Мөн иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, төрийн бус байгууллагын бүртгэлийн программ хангамжийг шинээр боловсруулах ажлыг эхлүүлж, төрийн бус байгууллагын бүртгэл, түүвэрлэлт хийх хэсгийг дуусгалаа.

Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд байгууллагын интернет сүлжээнд ашиглагдаж байгаа 44 хэрэглэгчийн компьютерт үзлэг шалгалтыг хийж, дүнг байгууллагын даргад хуудсаар танилцуулан хортой код илэрсэн нэг хэрэглэгчийн компьютерт зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар албан даалгаврын 1.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх үүднээс тоон гарын үсэг ашиглах таван албан хаагчийн

мэдээлэл, тоон гарын үсгийг байгууллагад ашиглах 20191209 дугаартай гэрээ, тоон гарын үсэг олгохыг хүссэн албан хаагчдын өргөдлийг Үндэсний дата төв УТҮГ-т тус тус хүргүүлэн ажиллав.

#### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6,2 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 12 дугаар сард 6,2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 5,4 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 12 дугаар сарын байдлаар 5 тэрбум 398 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 2 тэрбум 25 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

#### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 11 дүгээр сарын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, мөн сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

“Эрдэм сургалт судалгааны хүрээлэн” төрийн бус байгууллагад тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл болон албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авахад туслалцаа үзүүллээ.

Тус байгууллагын 2019 оны үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээнд тулгуурлан эрсдэлийг тодорхойлж удирдлагад танилцуулснаар тайланг албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүллээ.

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын 116 иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг гадаадын 12 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн буцалтгүй тусламжаар бүтээн байгуулахаар тохиролцсоны дагуу Өмнөговь аймагт Өмнөд бүс дэх газрын ажлын болон албан хаагчдын амины зориулалтын байрын шавийг тавилаа.

Хөшигийн хөндий дэх олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, нүүлгэн шилжүүлэх дэд ажлын хэсэг хуралдаж “Нью

Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-аас гаргасан саналын талаар хэлэлцэв. Мөн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга, Агаарын замын боомт хариуцсан газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нар “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн гүйцэтгэх захирал н.Мэргэнтэй уулзаж ирэгчийн танхимд байрлах тус газрын гурван өрөө, явагчийн танхимд байрлах нэг өрөөний зохион байгуулалт, ашиглалтын талаар хэлэлцэж тохирсон.

Үйл ажиллагаа явуулж буй хилийн 14 боомтод ажлын өдрийн 09:00, 16:00 цагуудад хил нэвтрэлт, онцлог нөхцөл, удирдлагын үүрэг, даалгаврыг нийт 20 удаа, орон нутаг дахь төлөөллийн нөхцөл байдлын мэдээг 21 удаа авч, бүртгэлийн дэвтэрт хөтлөн ажиллалаа. Түүнчлэн байгууллагын даргын 2019 оны 08 дугаар албан даалгавар гарсантай холбогдуулан орон нутаг дахь газруудаас гадаад иргэдийн хил нэвтрэлт, хил дээрээс буцаасан тоон мэдээг өдөр бүр нэгтгэж удирдлагад танилцуулан ажиллаж байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР